



**МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 3 сарын 19 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах,
тайлан гаргах, хяналт тавих журам” батлах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.8, 10.9 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.10, 10.11 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “аймаг, нийслэлийн сонгуулийн хороо /гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий төв комисс/-ны сонгуулийн зардлын тайлан”-ийн маягтыг 2 дугаар хавсралтаар, “сум, дүүргийн сонгуулийн хороо /салбар комисс/-ны сонгуулийн зардлын тайлан”-ийн маягтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх шатны сонгуулийн хороодод, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны дарга /Д.Баяндүүрэн/-д даалгасугай.

ДАРГА



П.ДЭЛГЭРНАРАН

00000054

Сонгуулийн ерөнхий хорооны даргын
2021 оны 3 дугаар сарын 17 ны өдрийн
А/Н/ дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

СОНГУУЛИЙН ТӨСӨВ ХУВААРИЛАХ, ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАН ГАРГАХ, ХЯНАЛТ ТАВИХ, ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий төв комисс /цаашид “төв комисс” гэх/ Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулж, харьяалах сонгуулийн хороодод хуваарилан, зарцуулалтад хяналт тавьж ажиллана.

Хоёр. Сонгуулийн хороодод төсөв хуваарилах

2.1.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна.

2.2.Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст дараах зардлыг хуваарилна:

2.2.1.сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал;

2.2.2.сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал;

2.2.3.сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал;

2.2.4. дүн мэдээ дамжуулах зардал;

2.2.5.санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал;

2.2.6.сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалт, сурталчилгааны зардал;

2.2.7.сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал;

2.2.8.бичиг хэргийн зардал;

2.2.9.шуудан, холбооны зардал;

2.2.10.унааны зардал;

2.2.11.албан томилолтын зардал;

2.2.12. болзошгүй зардал

2.3. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс Сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн тайлбар, аргачлал, байгуулагдсан сум, дүүргийн болон хэсгийн хорооны тоо, түүнд ажиллах гишүүдийн тоог харгалзан сум, дүүргийн сонгуулийн хороо, салбар комисст дараах зардлыг хуваарилна:

2.3.1. санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал;

2.3.2. сургалтын зардал

2.3.3. сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал;

2.3.4. бичиг хэргийн зардал;

2.3.5. шуудан холбооны зардал;

2.3.6. унааны зардал;

2.3.7. албан томилолтын зардал;

2.3.8. сонгуулийн байгууллагын ажилтан болон даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал;

2.3.9. болзошгүй зардал

Гурав. Сонгуулийн зардлын дансыг ашиглах, зардлыг зарцуулах, түүнд хяналт тавих

3.1. Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын дансыг Сангийн яамны Төрийн сангийн газарт нээлгэн, сонгууль дууссаны дараа зохих журмын дагуу хаалгана.

3.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, сонгуулийн хорооны даргын захирамжаар томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна.

3.3. Аймаг, нийслэл, дүүргийн сонгуулийн хорооны нягтлан бодогчоор дараах шаардлага хангасан хүнийг ажиллуулна.

3.3.1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 зүйлийн 3.1.7 дахь заалтын дагуу магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэглэлээр төгссөн байх;

3.3.2. төсвийн байгууллагад нягтлан бодогчоор 3-аас доошгүй жил ажилласан, бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх.

3.4. Төрийн сангийн газарт нээлгэсэн сонгуулийн хорооны зардлын дансыг зөвхөн Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн, орон нутгийн сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагаанд ашиглах бөгөөд бусад үйл ажиллагаанд ашиглахыг хориглоно.

3.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс нь орон нутгийн төрийн сан болон арилжааны банкинд харилцах болон жижиг мөнгөн сангийн данс нээлгэхийг хориглоно.

3.6. Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна.

3.7. Байгууллага, хувь хүнтэй хийх төлбөр тооцоог анхан шатны баримт болон холбогдох шийдвэрийг үндэслэн бэлэн бусаар буюу дансаар дамжуулан хийнэ.

3.8. Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

3.9. Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг Сонгуулийн ерөнхий хорооны дансанд буцаан төвлөрүүлнэ.

3.10. Сонгуулийн ерөнхий хороо нь Төрийн сан болон орон нутгийн аудитын байгууллагаар дамжуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтанд тус тус хяналт тавина.

Дөрөв. Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөх, гүйцэтгэлийн тайлан гаргах

4.1. Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж, бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө.

4.2. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын тайлан дараах хэсгээс бүрдэнэ:

4.2.1. сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичиг;

4.2.2. тайлангийн товч танилцуулга, тодруулга;

4.2.3. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийн нэгдсэн тайлан;

4.2.4. аудитын дүгнэлт /аймаг, нийслэлийн аудитын газраар гаргуулна/

4.2.5. дансны орлого, зарлага, хяналтын хуулга

4.2.6. дансны үлдэгдлийн баталгаа

4.2.7. санхүүгийн баримтыг архивт хүлээлгэж өгсөн тухай акт бичиг

4.3. Сум, дүүргийн сонгуулийн хороо болон салбар комиссын сонгуулийн зардлын тайлан дараах хэсгээс бүрдэнэ:

4.3.1. сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичиг;

4.3.2. тайлангийн товч танилцуулга, тодруулга;

4.3.3. сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлан;

4.3.4. санхүүгийн анхан шатны баримтууд /хүлээлгэн өгсөн акт/

4.4. Сум, дүүргийн сонгуулийн хорооны болон салбар комиссын дарга, нягтлан бодогч нар 4.3-т заасан тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 3 хоногийн дотор гарган аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комисст, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын дарга, нягтлан бодогч нар энэ журмын 4.3-т заасан тайланг нэгтгэн 4.2-т заасны дагуу нэгдсэн тайланг сонгуулийн санал хураалт дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж Сонгуулийн ерөнхий хороонд тус тус хүлээлгэж өгнө.

4.5. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нэгдсэн тайланг аймаг, нийслэлийн аудитын байгууллагаар хянуулан дүгнэлт гаргуулсан байна.

4.6. Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны санхүүгийн анхан шатны баримтын хамт архивын нэгж болгон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын архивт албан ёсоор хүлээлгэн өгнө.

4.7. Төв комиссын нягтлан бодогч салбар комиссоос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч төв комиссын анхан шатны баримтын хамт архивын нэгж болгон Сонгуулийн ерөнхий хороонд албан ёсоор хүлээлгэн өгнө.

Тав. Зардлын тайланг хянах

5.1. Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн зардлын тайланг аймаг, нийслэлийн сонгуулийн хороо, төв комисс тус бүрээр хянан хүлээн авч нэгтгэн сонгуулийн зардлын гүйцэтгэлийн нэгдсэн тайлан гаргана.


5.2. Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн зардлын нэгдсэн тайланг хуульд заасны дагуу Төрийн аудитын байгууллагаар хянуулж дүгнэлт гаргуулна.

Зургаа. Хариуцлага

6.1. Сонгуулийн хууль тогтоомж болон энэ журамд заасныг зөрчвөл холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

----oOo---

Сонгуулийн ерөнхий хорооны даргын
 2021 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн
 А/Н дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**..... АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН ХОРОО
 /ГАДААД УЛСАД БАЙГАА ИРГЭДЭЭС САНАЛ АВАХ АЖЛЫГ ЗОХИОН
 БАЙГУУЛАХ, НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮҮРЭГ БҮХИЙ
 ТӨВ КОМИСС/-НЫ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

Тайлан гаргасан огноо:

№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал			
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал			
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал			
4	Дүн мэдээ дамжуулах зардал			
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал			
6	Сургалт, сурталчилгааны зардал			
7	Сонгуулийн байгууллагын ажилтан болон мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал			
8	Бичиг хэргийн зардал			
9	Шуудан, холбооны зардал			
10	Унааны зардал			
11	Албан томилолтын зардал			
12	Болзошгүй зардал			
ДҮН				

Жич: Зардлын гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлтийг дотор нь нарийвчлан задалж болно.

ТАЙЛАН ГАРГАСАН:
 Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо
 /төв комисс/-ны дарга /
 Тэмдэг
 Нягтлан бодогч..... /

Сонгуулийн ерөнхий хорооны даргын
2021 оны 3 дугаар сарын 12 ны өдрийн
А.Н. дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

..... АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
..... СУМ, ДҮҮРГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО
/САЛБАР КОМИСС/-НЫ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

Тайлан гаргасан огноо:

№	Зардлыннэр	Төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал			
2	Сургалтын зардал			
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал			
4	Бичиг хэргийн зардал			
5	Шуудан холбооны зардал			
6	Унааны зардал			
7	Албан томилолтын зардал			
8	Сонгуулийн байгууллагын ажилтан болон даамал, нөөц даамлын тухайн сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал			
9	Болзошгүй зардал			
ДҮН				

Жич: Зардлын гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлтийг дотор нь нарийвчлан задалж болно.

ТАЙЛАН ГАРГАСАН:

Сум, дүүргийн сонгуулийн хороо
/салбар комисс/-ны дарга..... /
Тэмдэг
Нягтлан бодогч /